

**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР
ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН**

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Цэцэгмаа Нэр: Уртнасан Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Төрийн байгуулалтын байнгын хороо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга: Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна.”, мөн зүйлийн 4.2 дахь хэсэгт “Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, ...Төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулах үе шатыг баримтлан дараах ажиллагааг хийлээ. Үүнд: 1/ Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Цэцэгмаа овогтой Уртнасан нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно. 2/ Байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны 06 дугаар тогтоолыг баталж 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоосон бөгөөд сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг томилсон.	

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд

-Нэр дэвшигчийн тухай мэдээлэл, тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг parliament.mn буюу Улсын Их Хурлын цахим хуудаст 14 хоног байршуулсан.

-Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан зар мэдээллийн дагуу ажиглагч, оролцогчоор бүртгүүлэх хүсэлт ирүүлээгүй.

4/2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэх бөгөөд сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, С.Бямбацогт, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, А.Ганбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, С.Зулпхар, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаатар, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ч.Ундрэм, Б.Чойжилсүрэн, Ө.Шижир, Б.Энхбаяр, Д.Энхтуяа нар оролцсон болно.

5/Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Ц.Уртнасанг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилуулахаар нэрийг нь дэвшүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулсан болно.

6/Нэр дэвшигч Ц.Уртнасан нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар, Л.Гантөмөр нар асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Батжаргал, Ж.Баярмаа нар нэр дэвшигчид хандаж үг хэллээ.

Улсын Их Хурлын гишүүн А.Ганбаатар Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр сонгогдвол сонгуульд иргэд саналаа идэвхтэй өгөх, ирцийг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг 4 жил сурталчлах төсөв хангалттай эсэх, уг ажлын төсвийг нэмэгдүүлэх талаар санаачилгатай ажиллах, гадаад улсад буй иргэдийн саналыг технологийн дэвшлийг ашиглан авах талаар ямар шийдэл санал болгох тухай, сонгуулийн санал авах өдрийг Баасан гаргаас бусад ажлын өдөр зохион байгуулах тал дээр зарчим гаргаж ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр сонгуульд саналаа идэвхтэй өгөх ирцийг нэмэгдүүлэх тал дээр олон улсын туршлагыг нэвтрүүлэх, санал худалдаж авах зорилгоор мөнгө тарааж буй явдлыг хаах, гэхдээ хуулийн хатуу өндөр ялаар зохицуулж болохгүй бөгөөд өөр шийдэл олох, сонгогчдын нэрсийн жагсаалт бодит эсэх эргэлзээтэй байдаг, үүнтэй холбоотой технологийн шийдэл олох, цэргийн ангиудын санал хураалтад онцгой анхаарах тухай тус тус асуулт асууж хариулт авлаа. Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нэр дэвшигчид мөрийн хөтөлбөр танилцуулах сэтгүүлийг нэгтгэж тараах, ухуулагч гэдэг нэрийг өөрчлөх болон тоог хязгаарлах, сонгуулийн санал авах өдрийг Баасан гаргаас өөр өдөр зохион байгуулах, мөнгөний нөлөөллийг багасгах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал 2027, 2028 онд болох сонгуулиудын бэлтгэл ажлыг сайтар хангах, санал тоолох машины бэлэн байдал, эрх зүйн орчныг сайжруулах тал дээр анхаарах тухай, Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар мэдээллийн технологийн мэргэжилтэн хүний хувьд техник, программ хангамжийн тал дээр анхаарах, шилжилт хөдөлгөөн, сонгогчдын боловсролд анхаарах шаардлагатай тухай тус тус үг хэлсэн болно.

8/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жавхлан хааж үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу уг асуудлаар нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд нэр дэвшигч тухай албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргаж, тухайн тайланг нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах зохицуулалттай. Сонсголын тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж эцсийн шийдвэр гаргах болно гэдгийг танилцуулав.

3 Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь

/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдах талаар/

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт

“...Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо...төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасан түүнчлэн, Монгол Улсын Их хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагт Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

4 /Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшүүлсэн Цэцэгмаа овогтой Уртнасанг дэвшүүлсэн.

1/Нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдвол хэрэгжүүлэх ажлын чиглэлийнхээ тухай:

-Сонгуулийн төв байгууллагын бүтээмж, менежментийн соёлыг шинэ түвшинд гаргана.

-Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх ажлыг тасралтгүй явуулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

-Мэдээллийн технологийн шинэ шийдлүүдийг нэвтрүүлнэ.

-Төрийн албаны хараат бус, ёс зүйтэй байх зарчмыг баримтлан ажиллана.

-Улс төрийн намуудын санхүүжилтэнд хяналт тавих ажлыг сайжруулж ажиллана.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Цэцэгмаа овогтой Уртнасангийн ирүүлсэн материал болон сонголын үр дүнг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшүүлэхийг санал нэгтэйгээр дэмжлээ.

---oOo---

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНД САНАЛ БОЛГОСОН НЭР ДЭВШИГЧИЙН ТАЛААРХ СОНСГОЛЫН ТАЙЛАН

Товч удирдамж: Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нь сонсголын тайланг бичихэд энэхүү загварыг ашиглана. Тайланг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулах тул тайланд гэрийн хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар зэрэг хүний хувийн нууцад хамаарах мэдээллийг, мөн нэр дэвшигчийн талаар ярилцлага өгсөн хүний нэр, түүнийг таних шинжийг бичихгүй.

Нэр дэвшигчийн товч танилцуулга	
1	Эцэг/эхийн нэр: Нэргүй Нэр: Мягмар Хүйс: Эрэгтэй Нэр дэвшүүлсэн байгууллага: Төрийн байгуулалтын байнгын хороо
2	Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал
	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн
Сонсгол, түүний үе шат, явуулсан ажиллагааны танилцуулга:	
<p>Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Хороо нь есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн хоёр нь орон тооны, долоо нь орон тооны бус байна.”, мөн зүйлийн 4.2 дахь хэсэгт “Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, ...Төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтад заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулах үе шатыг баримтлан дараах ажиллагааг хийлээ. Үүнд:</p> <p>1/Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос нэр дэвшүүлсэн Нэргүй овогтой Мягмар нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан “нэр дэвших тухай хүсэлт”-ийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.</p> <p>2/Байнгын хорооны 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг үндэслэн “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны 06 дугаар тогтоолыг баталж 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулахаар тов тогтоосон бөгөөд сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхланг томилсон.</p>	

3/Сонсголын бэлтгэл хангах хүрээнд

-Нэр дэвшигчийн тухай мэдээлэл, тов, хугацаа, сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг parliament.mn буюу Улсын Их Хурлын цахим хуудаст 14 хоног байршуулсан.

-Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан зар мэдээллийн дагуу ажиглагч, оролцогчоор бүртгүүлэх хүсэлт ирүүлээгүй.

4/2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэнээр ирц бүрдсэн бөгөөд сонсголд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, О.Алтангэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Э.Болормаа, С.Бямбацогт, Ж.Батжаргал, Ж.Баярмаа, А.Ганбаатар, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Т.Доржханд, С.Зулпхар, Ч.Лодойсамбуу, Л.Мөнхбаатар, Э.Одбаяр, Б.Пүрэвдорж, Ц.Туваан, Ч.Ундрам, Б.Чойжилсүрэн, Ө.Шижир, Б.Энхбаяр, Д.Энхтуяа нар оролцсон болно.

5/Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Н.Мягмарыг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилуулахаар нэрийг нь дэвшүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Б.Жавхлан танилцуулсан болно.

6/Нэр дэвшигч Н.Мягмар нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулсан.

7/Нэр дэвшигчийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа, Ч.Лодойсамбуу нар асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар, Ж.Баярмаа нар нэр дэвшигчид хандаж үг хэлсэн болно.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа сонгууль хэр шударга явагддаг талаар нэр дэвшигчийн бодол, сонгуулийн үеийн мөнгө тараалтыг багасгах, тараасан этгээдүүдэд хуулийн хариуцлага хүлээлгэн эргүүлэн татдаг болох талаар хуулийн зохицуулалт, өөрчлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуу сонгуулийн ирц тааруу байгаа гол шалтгааны тухай, сонгуулийн санал тоолох төхөөрөмжийн эрсдэл дагуулж байна гэсэн дүгнэлтийг тодруулж асуулт асууж, хариулт авсан. Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар 18-35 насны залуучуудын нийгмийн идэвх муу байдаг зүй тогтол байдаг ч нэмэгдүүлэх талаар илүү санаачилгатай ажиллах, гадаад улсад байгаа иргэдээ технологийн дэвшил, шинэ шийдэл ашиглан сонгуульд өргөнөөр оролцуулах тухай, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа сонгуульд оролцох оролцоог нэмэгдүүлэх, сонгогчдын нэрсийн бүртгэлийг сайжруулах, санал авах өдрийг Баасан гаргаас өөр өдөр товлох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал гадаад улсад оршин суугаа монголчуудынхаа дунд сонгуулийн санал авах ажил зохион байгуулах ажил нь эх оронтойгоо холбоотой байх мэдрэмжийг өгдөг тул сонгуульд санал өгөх хүртээмжийг нэмэгдүүлж, хөнгөвчлөх тал дээр анхаарч ажиллах талаар тус тус үг хэлсэн болно.

8/Сонсголыг Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жавхлан хааж үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Б.Жавхлан: Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу уг асуудлаар нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулагдлаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусган, холбогдох бусад мэдээллийг хавсаргаж, тухайн тайланг нэр дэвшигч, түүний санал болгосон

этгээдэд хүргүүлж Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах зохицуулалттай. Сонсголын тайланг Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт гарган чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, эцсийн шийдвэр гаргах болно гэдгийг танилцуулав.

3 Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь
/Нийтийн сонсголын тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Томилгооны сонсгол зохион байгуулах журмын дагуу явагдах талаар/

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт "...Хорооны гишүүний тавыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо...төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилно." гэж заасан, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131 дүгээр зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 10.00 цагт Төрийн ордны "Үндсэн хууль" танхимд зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд 2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргасан болно.

/Байнгын хороо цуглуулсан бүх нотлох баримт, мэдээлэл, сонсголын дүнд тулгуурлан нэр дэвшигчийн хууль зүйн мэдлэг, ур чадвар, туршлага, ёс зүй, зан төлөвийг үнэлж нэр дэвшсэн албан тушаалд харгалзах шаардлагыг тухайн нэр дэвшигч хангасан, эсхүл хангаагүй гэдгийг нэгтгэн дүгнэж үндэслэлээ тодорхой, ойлгомжтой бичнэ./

Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд Нэргүй овогтой Мягмарыг нэр дэвшүүлсэн.

1/Нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилогдвол хэрэгжүүлэх ажлын чиглэлийнхээ тухай:

-Сонгуулийн ерөнхий хорооны хараат бус байдал, эрх зүйн орчинг сайжруулах талаар хуулийн салбарт ажилласан туршлагаа ашиглаж ажиллана.

-Эрдэм шинжилгээний байгууллага, багш, судлаачдын оролцоог нэмэгдүүлнэ.

-Санал тоолох төхөөрөмж, мэдээлэл дамжуулах болон хадгалах системийн аюулгүй байдлыг олон улсын стандартад нийцүүлэн тогтмол аудит, хөндлөнгийн үнэлгээнд хамруулах, кибер аюулгүй байдлын эрсдлийн удирдлагыг боловсронгуй болгох, иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх зорилгоор системийн ажиллагааны талаарх мэдээллийг ил тод хүргэж ажиллана.

4

-Сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулагдаж буй төсвийн хөрөнгийг үр ашигтай, ил тод зарцуулах, төсвийн төлөвлөлтийг хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц, эрсдэл болон хэрэгцээнд суурилан төлөвлөж ажиллана.

-Анх удаа санал өгөх иргэдэд зориулсан сургалт, мэдээллийн хөтөлбөр хэрэгжүүлэх, их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургуулиудын иргэний боловсролын агуулгыг дэмжих, нийгмийн сүлжээ болон дижитал платформ ашиглан залуучуудад чиглэсэн сонгогчдын боловсролын шинэ хэлбэрүүдийг хөгжүүлэн ажиллана.

-Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, алслагдсан бүс нутгийн сонгогчдын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хүртээмжтэй бодлогыг хэрэгжүүлэх болно.

2/Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Нэргүй овогтой Мягмарын ирүүлсэн материал болон сонголын үр дүнг үндэслэн Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшүүлэхийг санал нэгтгэйгээр дэмжлээ.

---oOo---